**ОРХОН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 07-ны өдөр Дугаар А/17 Эрдэнэт

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг
уртасгасан цагаар ажиллуулах тухай

Монгол улсын нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.4 дэх заалт, ЭМС-ын 2017 оны А/356, 2020 оны 482 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Томуу томуу төст өвчний халдварын тархалтын төвшинтэй холбоотой бага насны хүүхдийн дунд амьсгалын замын цочмог халдварын шалтгаант уушигны хатгалгаа, ,хүндрэл нэмэгдэж байгаа тул сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажиллах хуваарийг 2022 оны 03 сарын 07-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 08:00-20:00 цаг, амралтын өдрүүдэд 10:00-16:00 цаг хүртэл уртасгасан цагаар ажиллуулсугай.

2. Өвчтэй хүүхдийг ХӨЦМ-ийн дагуу гэрээр эмчилгээнд хамруулж, томуу томуу төст өвчнөөс сэргийлэх сургалт сурталчилгааг эрчимжүүлэн, хийгдсэн үзлэг, эргэлт, утас, цахим тандалт, томуугийн сургалт сурталчилгааны тоог өдөр бүр загварын дагуу ЭМГ-т мэдээлж ажиллахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай .

3. Сум,өрхийн эрүүл мэндийн төвийн томуугийн тусламж үйлчилгээнд хяналт тавьж ажиллах ЭМГ-ын мэргэжилтнүүдийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ТТӨ-ний үеийн тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Уртасгасан цагаар ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтний нэмэгдэл хөлсийг бодож олгохыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт, уртасгасан цагийн зохицуулалтад хяналт тавьж ажиллахыг сум, өрхийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /А.Баярхүү/-д, ТТӨ-ний үеийн тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээг ЭМБ-уудаас авч нэгтгэхийг халдвар судлаач /Б.Билгүүн/ нарт тус тус даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

9043446 2070030036

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 03 дугээр сарын
07-ний өдрийн 1/17 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн томуугийн тусламж үйлчилгээнд хяналт тавьж ажиллах ЭМГ-ын мэргэжилтнүүдийн хуваарь

| № | ЭМБ-ын нэр | Хяналт тавих мэргэжилтний нэрс | Хийх чиглэл |
|---|---|---|---|
| 1 | Анхны- Оч | ЭМГ-ын УАУСЗТҮХМэргэжилтэн М.Бямбасүрэн | -ТТӨ-ний үеийн тусламж үйлчилгээний зохион байгуулалт, шуурхай байдал<br>-Бүртгэл мэдээллийг тогтмол мэдээлэх<br>-Уртасгасан цагаар ажиллаж байгаа байдалд хяналт тавих<br>-0-5 хүртэл насны хүүхдийн хяналт<br>-Хүүхдийн гэрийн эмчилгээ<br>-Утас, цахим хяналт<br>-ТТӨ-нөөс сэргийлэх ЭМСС хийгдэж байгаа эсэх<br>-Эм,эмнэлгийн хэрэгслийн хангалт хүртээмжийг үнэлэх |
| 2 | Мэндцэцэн | ЭМГ-ын ХБӨТСХМэргэжилтэн А.Хонгорзул | |
| 3 | Нийцэл | ЭМГ-ын ОЭТХМэргэжилтэн Г.Оюунтөгс | |
| 4 | Үйлсбадрах | ЭМГ-ын БЗДХГХАХМэргэжилтэн С.Дулмаа-Юмлаа | |
| 5 | Мөнхийн гэгээ | ЭМГ-ын ЭМССХМэргэжилтэн Ө.Наранзаяа | |
| 6 | Учралтбаяр | ЭМГ-ын ЭМСМХМэргэжилтэн Г.Итгэл | |
| 7 | Энхжихмандариваа | ЭМГ-ын ЭБЗАБХМэргэжилтэн О.Анхбаяр | |
| 8 | Мөнхсүндрэл | ЭМГ-ын ХТХАБХМэргэжилтэн П.Баярмаа | |
| 9 | Жаргалант сумын ЭМТ | ЭМГ-ын Халдвар судлаач Б.Билгүүнэ | |
| 10 | БОЭТ-ийн хүүхдийн тасаг | ЭМГ-ын ХТҮХМэргэжилтэн П.Хишгээ | |

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05 дугээр сарын
07-ний өдрийн A/17 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

9043446 2020030036

ТТӨ-ний үеийн тусламж үйлчилгээний .... өдрийн мэдээний загвар

...........ЭМБ-ын нэр огноо

| № | ЭМБ-ын нэр | Нийт үзлэг | Үүнээс ТТӨ-тэй хүний тоо | Үүнээс ТТӨ-тэй жирэмсэн эхийн тоо | Үүнээс ТТӨ-тэй 5 хүртэл насны хүүхдийн тоо | Үүнээс гэрийн эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | Үүнээс АЗХӨ-ний шалтгаант эмнэлэгт хэвтүүлсэн хүүхдийн тоо | Утас, цахим тандалтад хамрагдсан 5 хүртэл насны хүүхдийн тоо | ТТӨ-нөөс сэргийлэх ЭМСС хийгдсэн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |